



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/63

Номгон

Эрдэнэмандал сургуулийн баруун талын  
4 замын уулзварт гэрлэн дохио суурилуулах  
ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах  
тендерийн үнэлгээний хороо  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2, 50 дугаар зүйлийн 50.1.2 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор сумын Эрдэнэмандал сургуулийн баруун талын 4 замын уулзварт гэрлэн дохио суурилуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Д.Сарангарав

Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Баасанбат

Аймгийн засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Мөнгөнсүх

Цагдаагийн газрын Холбоо мэдээллийн ахлах инженер, цагдаагийн хошууч

Н.Цэдэвсүрэн

Хараат бус гишүүн

Нарийн бичгийн дарга:

Ж.Анхцэцэг

Аймгийн Худалдан авах ажиллагааны газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж, авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахыг үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (П.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

626010145